



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цог-Өрнөх ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/031/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2026 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас:70533539 Цахим хаяг:usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК Захирал: Г.Энхмаа Утас: 77450279 99040059 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн зорилтот түвшний тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	9
3.2 Албан шаардлага	9
3.3 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 317
танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГЦЭЦИЙ
СУМЫН ЦОГ-ӨРНӨХ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.АРДТҮМЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цогтцэций сумын "Цог-Өрнөх" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 1,936.8 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 153.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, бусад үйл ажиллагааны 145.5 сая төгрөгийн орлого хүлээн авч, хуримтлагдсан элэгдлийн 1,375.0 сая төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч, 45.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацаанд Цогтцэций сумын Засаг даргын захирамжийн дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан хөрөнгөтэй холбоотой нийт 738.5 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн

4626050437

ҮНЭ: Бичиг хэргийн 2025 оны ЦТА-н дүгнэлт Төсөл, Дөх

16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
2	Эргэлтийн хөрөнгө	781,067,228.88	1,176,415,133.74
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	652,402,638.80	549,913,141.07
4	Бараа материал	128,664,590.08	573,994,952.68
5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		52,507,039.99
	Эргэлтийн хөрөнгийн дүн	781,067,228.88	1,176,415,133.74
	Эргэлтийн бус хөрөнгө	18,144,219,493.95	19,074,036,266.52
6	Үндсэн хөрөнгө	18,034,619,493.95	17,635,706,266.52
7	Биет бус хөрөнгө	109,600,000.00	1,438,330,000.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,144,219,493.95	19,074,036,266.52
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,925,286,722.83	20,250,451,400.26
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	Өр төлбөр	15,847,662,749.04	15,798,350,236.11
	Богино хугацаат өр төлбөр	13,349,531.90	4,000,000.00
8	Татварын өр	13,349,531.90	
9	Бусад богино хугацаат өр төлбөр		4,000,000.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,349,531.90	4,000,000.00
	Урт хугацаат өр төлбөр		
10	Бусад урт хугацаат өглөг	15,834,313,217.14	15,794,350,236.11
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	15,834,313,217.14	15,794,350,236.11
	Өр төлбөрийн нийт дүн	15,847,662,749.04	15,798,350,236.11
	Эздийн өмч	3,077,623,973.79	4,452,101,164.15
11	Өмч: - төрийн	4,106,162,656.10	4,106,162,656.10
12	Халаасны хувьцаа	109,600,000.00	1,438,330,000.00
13	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	98,782,750.89	98,782,750.89
14	Хуримтлагдсан ашиг(алдагдал)	(1,236,921,433.20)	(1,191,174,242.84)
	Эздийн өмчийн дүн	3,077,623,973.79	4,452,101,164.15
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,925,286,722.83	20,250,451,400.26

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,597,299,139.05	2,082,278,066.99
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,691,291,364.37	3,304,347,603.58
3	Нийт ашиг/алдагдал/	(93,992,225.32)	(1,222,069,536.59)
4	Хүүний орлого	7,211,205.63	9,721,967.31
5	Бусад орлого	421,336,622.68	1,518,352,020.03
6	Ерөнхий ба удирдлагын зардал	140,403,798.82	248,921,277.33
7	Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз (гарз)		5,627,665.72
8	Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал/	194,151,804.17	57,083,173.42
9	Орлогын албан татварын зардал	19,415,180.42	5,708,317.34
10	Татварын дараах ашиг алдагдал	174,736,623.75	51,374,856.08
11	Тайлант үеийн цэвэр ашиг/ алдагдал/	174,736,623.75	45,747,190.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,869,339,688.63</u>	<u>2,461,001,617.31</u>
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,869,339,688.63	2,461,001,617.31
4	Мөнгөн зарлагын дүн	<u>1,588,048,126.90</u>	<u>2,351,700,933.26</u>
5	Ажиллагчдад төлсөн	546,417,697.00	870,337,238.00
6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	163,800,805.46	260,343,578.05
7	Бараа материал худалдан авахад төлсөн	428,551,862.49	511,810,859.44
8	Ашиглалтын зардалд төлсөн		5,885,744.00
9	Татварын байгууллагад төлсөн	160,033,356.97	321,217,717.99
10	Бусад мөнгөн зарлага	289,244,404.98	382,105,795.78
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>281,291,561.73</u>	<u>109,300,684.05</u>
12	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
13	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
14	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>90,845,168.18</u>	<u>211,790,181.78</u>
15	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	90,845,168.18	211,790,181.78
16	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(90,845,168.18)</u>	<u>(211,790,181.78)</u>
17	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
18	Мөнгөн орлогын дүн	-	-
16	Мөнгөн зарлагын дүн	-	-
20	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
21	Валютын ханшийн зөрүү	-	-
22	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>190,446,393.55</u>	<u>(102,489,497.73)</u>
23	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	461,956,245.25	652,402,638.80
24	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	652,402,638.80	549,913,141.07

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,215,762,656.10	98,782,750.89	(1,236,921,433.20)	3,077,623,973.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл	4,215,762,656.10	98,782,750.89	(1,236,921,433.20)	3,077,623,973.79
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			45,747,190.36	45,747,190.36
5	Өмчид гарсан өөрчлөлт	1,328,730,000.00			1,328,730,000.00

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цог-Өрнөх ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,544,492,656.10	98,782,750.89	(1,191,174,242.84)	4,452,101,164.15
----------	--	-------------------------	----------------------	---------------------------	-------------------------

2.5 Аудит хийсэн зорилтот түвшний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт		2024 оны	2025 оны		Эзлэх хувь	Өөрчлөлт	
		гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Өмнөх оноос	Төлөв-с
Нийт орлого		2,025,846.7	3,610,352.0	3,610,352.0	100.00	1,584,505.3	-
Үүнээс:	Үйл ажиллагааны орлого	1,542,724.4	2,087,010.7	1,946,544.7	53.92	544,286.3	(140,466.0)
	ДЭХ-ний орлого	ЦЭХ					-
		ДЭХ	733,791.6	1,013,106.3	1,095,512.0	30.34	361,720.4
	Цэвэр бохир усны орлого	801,721.6	799,560.3	808,539.4	22.40	6,817.8	8,979.1
	Бусад орлого	7,211.2	274,344.1	42,493.3	1.18	35,282.1	(231,850.8)
	Үйл ажиллагааны бус орлого	483,122.3	1,523,341.3	1,663,807.3	46.08	1,180,685.0	140,466.0
Нийт зардал		1,831,695.0	3,512,817.3	3,553,268.9	100.00	1,721,573.9	40,451.6
Үндсэн үйл ажиллагааны зардал		1,691,291.3	2,697,331.5	3,304,347.6	92.99	1,613,056.3	607,016.1
Үүнээс	түлш	93,296.8	84,000.0	68,129.2	1.92	(25,167.6)	15,870.8
	элэгдэл	440,771.6	1,456,823.1	1,495,713.2	42.09	1,054,941.6	38,890.1
	бусад тогтмол	1,157,222.9	1,156,508.4	1,740,505.2	48.98	583,282.3	583,996.8
Үйл ажиллагааны бус зардал		140,403.7	815,485.8	248,921.3	7.53	108,517.6	(566,564.5)
Татварын өмнөх ашиг /алдагдал/		194,151.7	97,534.7	57,083.10		(137,068.6)	(40,451.6)
Татварын дараах ашиг /алдагдал/		174,736.6	24,688.4	45,747.2		(128,989.4)	21,058.8

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,814.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 16,814.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 3,444.5 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тавигдаагүй.

3.2 Албан шаардлага

ИЛРҮҮЛЭЛТ: Тайлант онд тушаал шийдвэргүйгээр сургалтын төлбөрт 9,028.8 мянган төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг биелүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

3.3 Зөвлөмж

ИЛРҮҮЛЭЛТ: Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хамааралгүй гүйлгээг бичиж өртгийн дүнг 7,785.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар"-ыг зөрчсөн, байгууллагын НБББББ-т заасан дансны бичилтийг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан дансны бичилтийн дагуу зардлыг ангилж бичилт хийх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хамааралгүй гүйлгээг бичиж өртгийн дүнг 7,785.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.	1	7,785.2					1	7,785.2				
	Тайлант онд тушаал шийдвэргүйгээр сургалтын төлбөрт 9,028.8 мянган төгрөгийг төлсөн байна.	1	9,028.8			1	9,028.8						
	Дүн	2	16,814.0			1	9,028.8	1	7,785.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 171,904.0 мянган төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй.	1	171,904.0			1	171,904.0		
Нийт дүн	1	171,904.0			1	171,904.0		